

**ДОТООД АУДИТЫН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН
САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН
ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2023.09.28

ДОТООД АУДИТЫН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

I. Тайлангийн хураангуй

1.1 Нийтлэг үндэслэл

Санхүүгийн хяналт, аудитын үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний дагуу Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэсэн заалтыг үндэслэн дотоод аудит хийж дүгнэлт, илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2 Дотоод аудитын зорилго

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, үүсээд байгаа асуудлуудын нөхцөл байдлыг үнэлэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн үндэслэл, зөвлөгөө өгөх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх цаашдын арга хэмжээний санал боловсруулан гүйцэтгэх удирдлагад танилцуулах зорилготой.

1.3 Дотоод аудитын хамрах хүрээ

1.3.1 Шинжлэх ухааны сургуулийн 2018-2023 оны санхүүгийн үйл ажиллагаа

- Шинжлэх ухааны сургуулийн захиргаа
- Шинжлэх ухааны сургуулийн байгалийн ухааны салбар
- Шинжлэх ухааны сургуулийн нийгмийн ухааны салбар
- Шинжлэх ухааны сургуулийн хүмүүнлэгийн ухааны салбар

1.3.2 Тайлан мэдээ

- 2018-2022 он 2023 оны хагас улирлын санхүүгийн тайлан холбогдох хавсралтууд;
- 2018-2022 он 2023 оны хагас улирлын төсвийн гүйцэтгэлийн тайлан;
- Дээрх онуудын касс, харилцахын ерөнхий журнал гүйлгээ;
- 2021-2023 хичээлийн жилийн тайлан
- Дээрх онуудын хамрагдах /суралцагчийн хичээл сонголтын төлөвлөгөө, гүйцэтгэл, багшийн цагийн ногдлын гүйцэтгэлийн тайлан/

1.4 Баримталсан аудитын стандартууд: АОУС 2400, 2410, 2410A1, 2410A2, 2410A3, 2420, 2421, 2430, 2431, 2440, 2440A1

1.5 Ашигласан арга зүй: АОУС 2300, 2310, 2320, 2330

1.6 Нотлох зүйлийн хэлбэрүүд: Аман, баримтат, биет, дүн шинжилгээ

1.7 Тайлангийн үндсэн хэсэг

1.8 Товч дүгнэлт

1.9 Аудитын зөвлөмжүүд

УДИРТГАЛ

МУИС-ийн захирлын 2023 оны 08 дугаар сарын 23-ны 1/2048 тоот удирдамжаар Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж илэрсэн асуудалд чиглэсэн зөвлөгөө өгөх, цаашид үүсэх эрсдэлээс хамгаалах зорилгоор санал боловсрууллаа. Сургуулийн үйл ажиллагаанд аудит хийсэн гол асуудал нь санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх, үүсээд байгаа асуудлын үндэслэлийг гаргахад чиглэсэн. Санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэхэд хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан мэдээ, холбогдох хавсралт, албан ёсны тайлангуудын тоо мэдээ, холбогдох хүмүүсийн баталгаажуулж гарган өгсөн батламж мэдэгдлүүдэд тулгуурлав. Санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үнэлгээнд үйл ажиллагааны онцлогоос хамаарч бэлэн төлбөрийн хэрэгсэл их хэрэглэгддэг учир эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг эх үүсвэрийн гол бүрэлдэхүүн гэж авч үзлээ.

Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа, эрсдэлийн талаар холбогдох баримт бичигтэй танилцах, мэдээлэл олж авах;
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны талаар тайлбар танилцуулга сонсох, ярилцлага хийх;
- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд үүсээд байгаа асуудлуудын нөхцөл байдлыг үнэлэх;
- Дотоод аудитын тайлан бэлтгэж санал боловсруулан гүйцэтгэх удирдлагад танилцуулах.

Цаг хугацаа, хүний нөөц хязгаарлагдмал учир ерөнхий зургаар нь үнэлэх, асуудалд нөлөө ихтэй хэсгүүдийг нарийвчлах, зайлшгүй холбогдох хэсгүүдийг түүвэрлэн гүйцэтгэх, бодитой үнэн зөв өгөгдлөөр тоон шинжилгээг түлхүү хийн нотлох болон АОУС-уудыг арга зүйдээ ашигласан болно. Анхан шатны баримтын бүрдэл болоод бараа материал, хөрөнгийн оршин байгааг нягтлах хэсэгт харьцангуй бага гүйцэтгэл хийлээ.

НЭГ. ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ОДООГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1 Ерөнхий мэдээлэл

Шинжлэх ухааны сургуулийн бүтэц, зохион байгуулалтын хувьд сургуулийн захиргаа, салбар 3 сургууль гэсэн бүрэлдэхүүнтэй. Салбар сургуулиуд нь байгалийн ухааны 7 тэнхим, нийгмийн ухааны 6 тэнхим, хүмүүнлэгийн ухааны 8 тэнхимтэй 420 багш, 117 захиргаа, үйлчилгээний ажилчидтай, 5809 идэвхтэй суралцагчидтай үйл ажиллагаа явуулж байна.

1.2 Бүтэц, орон тоо, суралцагчид

№	Албан тушаалын ангилал	ШУС	ШУС- захиргаа	ШУС- НУС	ШУС- БУС	ШУС- ХУС
1	Багш	420	-	97	139	184
	<i>1.1.1 Профессор</i>	<i>58</i>		<i>15</i>	<i>26</i>	<i>17</i>
	<i>1.1.2 Дэд профессор</i>	<i>136</i>		<i>31</i>	<i>54</i>	<i>51</i>
	<i>1.1.3 Ахлах багш</i>	<i>135</i>		<i>24</i>	<i>31</i>	<i>80</i>
	<i>1.1.4 Багш</i>	<i>52</i>		<i>17</i>	<i>15</i>	<i>20</i>
	<i>1.1.5 Дадлагажигч багш</i>	<i>11</i>		<i>4</i>	<i>1</i>	<i>6</i>
	<i>1.1.6 Зөвлөх профессор</i>	<i>20</i>		<i>4</i>	<i>9</i>	<i>7</i>
	<i>1.1.7 Гэрээт багш</i>	<i>8</i>		<i>2</i>	<i>3</i>	<i>3</i>
	<i>1.1.8 Зочин багш</i>	<i>-</i>				
	<i>1.1.9 Лицей багш</i>	<i>-</i>				
2	Удирдах албан тушаалтан	4	1	1	1	1
3	Сургалтын үйлчилгээний ажилтан	12		4	4	4
4	Тэнхимийн туслах ажилтан	49		8	30	11
5	Мэргэжлийн албан хаагч	12		3	5	4
6	Техникийн болон гүйцэтгэх албан хаагч	40	2	8	17	13
	Дүн	537	3	121	196	217
	Суралцагчид	5809		2322	1382	2105
	<i>Бакалавр</i>	<i>4772</i>		<i>1998</i>	<i>1159</i>	<i>1615</i>
	<i>Магистрант</i>	<i>416</i>		<i>179</i>	<i>155</i>	<i>82</i>
	<i>Докторант</i>	<i>145</i>		<i>56</i>	<i>33</i>	<i>56</i>
	<i>Гадаад оюутан</i>	<i>476</i>		<i>89</i>	<i>35</i>	<i>352</i>

Эх сурвалж: СХЧББГ-ын мэдээнээс

2. Сургуулийн хөрөнгө, эх үүсвэрийн бүрэлдэхүүн


Шинжлэх ухааны сургуулийн захиргаа, салбар 3 сургуулийн 2018-2023.06 сарын санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох хавсралтууд, тайлангуудыг хамруулан нөхцөл байдалд үнэллээ. МУИС-ийн нийт хөрөнгийн дүн 2023 оны хагас улирлын тайлангаар нийт хөрөнгө 6,662.86 сая төгрөг байна. Үүний 67.6 хувь нь эргэлтийн хөрөнгө 32.3 хувь нь эргэлтийн бус хөрөнгө байна. Хөрөнгийг салбар сургуулиар харуулбал нийт хөрөнгийн 37.0 хувь нь Байгалийн ухааны салбарт, 26.0 хувь Хүмүүнлэгийн

ухааны салбарт, 26.0 хувь нь Нийгмийн ухааны салбарт, үлдсэн хувь нь тус сургуулийн захиргаанд байршиж байна. 2018-2023 оны хагас улирал хүртэл мөнгөн хөрөнгийн үлдэгдэл **6 дахин** буурсан, үндсэн хөрөнгө **73.8** хувийн элэгдэлтэй байгаа нь эх үүсвэр хумигдсаныг илтгэж байна. *Хавсралт 1. Шинжлэх ухааны сургуулийн хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц, хувь хэмжээ (2019-2021)*


2.1 Эргэлтийн хөрөнгө

2023 оны хагас улирлаар нийт эргэлтийн хөрөнгө 2.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнээс 1.2 тэрбум төгрөг нь мөнгөн хөрөнгө, 719.9 сая төгрөг нь авлага, 934.3 сая төгрөг бараа материал, 49.4 сая төгрөг урьдчилж орсон орлого байна. Тайлант оны эргэлтийн хөрөнгө сүүлийн 5-н жилд 2.8 дахин буурсан үзүүлэлттэй байна. Мөнгөн хөрөнгийн хуримтлал үндсэн үйл ажиллагаанд зарцуулагдан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл багассан байна. Сургалтын төлбөрийн авлага нь Сиси систем дээр хичээл сонголтын цуцлалттай холбоотойгоор үүссэн байна.

Зураг 1. Эх үүсвэр бүрдэлт, зарцуулалтын үйл явц.



Зураг 2. Салбар сургуулийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2023 оны хагас улирлын байдлаар харуулбал:



2.2 Эргэлтийн бус хөрөнгө

Хөрөнгийн төрөл		2023.06	2022	2021	2020	2019	2018
ШУС захиргаа	2.1 Үндсэн хөрөнгө	464.38	464.00	289.30	132.41	68.93	68.17
	Хуримтлагдсан элэгдэл	(186.27)	(164.47)	(137.20)	(44.23)	(25.84)	(20.35)
	ҮХ-ийн цэвэр дүн	278.11	299.53	152.10	88.18	43.09	47.82
	Үүнээс: Барилга	148.69	148.70	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	213.30	213.30	200.50	43.01	13.70	16.09
	Тавилга, хэрэгсэл	85.80	84.70	88.80	89.40	55.23	52.08
	Номын фонд	-	-	-	-	-	-
	2.2 Нийтийн тохижилт, бусад	16.59	17.30	-	-	-	-
	2.3 Биет бус хөрөнгүүд	-	-	-	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		278.11	299.53	152.10	88.18	43.09	47.82
ШУС НУС	2.1 Үндсэн хөрөнгө	1,600.16	1,564.50	1,417.10	1,264.29	1,321.21	1,020.70
	Хуримтлагдсан элэгдэл	(970.84)	(888.15)	(734.14)	(598.98)	(589.67)	(503.65)
	ҮХ-ийн цэвэр дүн	629.32	676.35	682.96	665.31	731.54	517.05
	Үүнээс: Барилга	-	-	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	970.82	943.38	860.55	727.06	796.14	583.40
	Тавилга, хэрэгсэл	416.32	415.83	364.72	356.05	350.26	335.11
	Номын фонд	148.50	140.76	127.30	116.65	110.28	102.09
	2.2 Нийтийн тохижилт, бусад	64.52	64.53	64.53	64.53	64.53	0.10
	2.3 Биет бус хөрөнгүүд	0.23	0.33	0.80	1.90	15.50	29.10
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		629.55	676.68	683.76	667.21	747.04	546.15
ШУС-БУС	2.1 Үндсэн хөрөнгө	9,934.84	9,862.03	9,129.68	8,895.44	8,482.15	8,253.97
	Хуримтлагдсан элэгдэл	(8,189.27)	(7,986.41)	(7,127.38)	(6,334.60)	(5,467.22)	(4,551.74)
	ҮХ-ийн цэвэр дүн	1,745.57	1,875.62	2,002.30	2,560.84	3,014.93	3,702.23
	Үүнээс: Барилга	228.95	228.95	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	8,556.04	8,494.67	8,036.29	7,798.09	7,455.64	7,226.70
	Тавилга, хэрэгсэл	892.40	885.33	847.33	861.17	792.81	806.12
	Номын фонд	255.85	251.41	246.06	236.18	233.70	221.15
	2.2 Нийтийн тохижилт, бусад	1.60	1.67	-	-	-	-
	2.3 Биет бус хөрөнгүүд	-	0.32	4.02	10.45	13.61	19.29
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,745.57	1,875.94	2,006.32	2,571.29	3,028.54	3,721.52
ШУС-ХУС	2.1 Үндсэн хөрөнгө	2,501.57	2,239.87	2,328.94	2,039.16	1,787.18	1,598.16
	Хуримтлагдсан элэгдэл	(1,380.36)	(1,258.76)	(1,250.74)	(1,063.39)	(1,036.42)	(999.36)
	ҮХ-ийн цэвэр дүн	1,121.21	981.11	1,078.20	975.77	750.76	598.80
	Үүнээс: Барилга	-	-	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	1,595.74	1,397.40	1,517.38	1,242.88	1,017.97	866.75
	Тавилга, хэрэгсэл	619.48	569.16	549.84	553.22	533.09	506.69
	Номын фонд	286.35	273.31	261.72	243.06	236.12	224.03
	2.2 Нийтийн тохижилт, бусад	-	-	-	-	-	0.69
	2.3 Биет бус хөрөнгүүд	1.83	3.49	7.16	11.22	15.27	3.31
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,123.04	984.60	1,085.36	986.99	766.03	602.11

Үндсэн хөрөнгийн элэгдлийн 2018 онд 35.7 хувьтай тэнцэхүйц, 2019 онд 59.5 хувьтай тэнцэхүйц, 2020 онд 69.3 хувьтай тэнцэхүйц, 2021 онд 65.6 хувьтай тэнцэхүйц, 2022 онд 30.0 хувьтай тэнцэхүйц хөрөнгө оруулалтыг хийжээ. Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны санхүүжилтийн хувь хэмжээг нэмэгдүүлэн тодорхой хэмжээний мөнгөн хуримтлалыг бий болгож чадаагүй байна.

2.3 Өр төлбөр ба өмч


2018-2023 оны хагас улирлын тайлангаар өр төлбөрийн үлдэгдэл 2,791.9 сая төгрөг буюу суурь оноос **2 дахин** өссөн үзүүлэлттэй байна. Богино хугацаатай өр төлбөрийн бүтцэд урьдчилж орсон орлого нь дийлэнх хувийг эзэлдэг ба энэ нь нийт өр төлбөрийн 98.8 хувь байна. Өөрөөр хэлбэл дансны өглөг нь нийт төлбөрийн дөнгөж 1.2 хувийг эзэлж байна. Хичээл сонголтоор төлбөрөө төлдөг механизм нь сургуулийн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй байгааг илтгэж байна.

2.4 Санхүүгийн үр дүн

Шинжлэх ухааны сургууль нь жил тутмын орлогын 85.5-93.5 хувийг зөвхөн өөрийн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэн ашиглалтын тогтмол зардал болон хөрөнгө оруулалтын

зарим хэсгийг төсвийн санхүүжилтээр санхүүжүүлдэг байсан бол дээд боловсролын тухай хуульд өөрчлөлт орж тогтмол зардлын санхүүжилт зогссон байна.

Зураг 3. Санхүүгийн үр дүн /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Сангийн тайлангийн үр дүнгийн тайлангаас

2.5 Санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үндсэн харьцаа

Санхүүгийн тогтворжилтын хувьд үзүүлэлтүүдийг нь өмнөх онуудтай харьцуулбал буурсан боловч төсвийн санхүүжилт болон бусад гадаад эх үүсвэрээс хараат бусаар үндсэн ажиллагааны орлогоороо урсгал зардал төдийгүй хөрөнгө оруулалтын хэсгийг санхүүжүүлэх боломж байгааг илтгэж байна.

Хүснэгт 2. ШУС-ийн санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын үндсэн харьцаа (2018-2022)

Үзүүлэлтүүд	Стандарт норм	2018	2019	2020	2021	2022
1. Санхүүгийн тогтворжилт						
1.1 Өөрийн хөрөнгийн оролцоо	≥ 50	89.91	91.63	88.42	86.38	71.57
1.2 Нийт өрийн харьцаа	≤ 1.0	0.11	0.09	0.13	0.16	0.40
1.3 Ажлын капитал (сая төг)		6,893.01	9,197.69	8,339.93	8,050.31	3,898.91
1.4 Санхүүгийн уян хатан байдал		58.36	66.74	65.91	67.21	50.40
1.5 Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт		0.84	0.88	0.83	0.81	0.56
2. Төлбөрийн чадвар						
2.1 Өнөөгийн боломж	0.2-0.3	5.34	7.69	4.01	4.08	1.75
2.2 Ойрын боломж	0.8-1.0	5.82	7.88	5.66	4.83	2.00
2.3 Эргэлтийн хөрөнгийн харьцаа	2:01	6.20	8.31	6.03	5.26	2.27
3. Хөрөнгийн өгөөж хувиар						
3.1 Орлогын нэг төгрөгт ногдох зардал	≥ 1	0.94	0.94	1.05	1.03	1.16

2.6 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогоо бүрдүүлсэн байдал, зардлыг төлөвлөсөн хэмжээнд зориулалтын дагуу зарцуулсан байдал, хөрөнгө мөнгөний үр өгөөж, зарим зардлыг хэмнэлттэй захиран зарцуулах боломжоо олж харах, өртгийг бодитой тооцсон эсэх, дунд хугацааны төлөвлөлт болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлсэн эсэх, үр дүнг дээшлүүлсэн эсэхийг тодорхойлох үүднээс шинжиллээ. ШУС-ийн захиргаа,

Хүмүүнлэгийн ухааны салбар, Нийгмийн ухааны салбар, Байгалийн ухааны салбар сургуулийн 2018-2023 оны төсвийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийг хамрууллаа. 2018-2022 оны хэсэгт төсвийн гүйцэтгэлийн өгөгдлүүдэд төсвийн бүтцийн шинжилгээ, анализ хийн суурь түвшнийг тогтоох, 2023 оны хагас улирлын төсвийн гүйцэтгэлд эрх үүрэг, хариуцлага, сахилга баттай холбогдох хэсэгт илүү ач холбогдол өглөө. Шинжлэх ухааны сургуулийн төсвийн орлогын гүйцэтгэлийн бүтцийг сүүлийн 5-н жилийн дунджаар харуулбал нийт орлогын **93.16 хувийг сургалтын төлбөр** (дотоод тооцооны орлого нэмэгдсэн)-ийн орлогоос, 2.81 хувийг МУИС-ийн төвлөрүүлсэн бодлогын санхүүжилтээс, 3.2 хувийг эрдэм шинжилгээний төсөл болон сургалтаас бусад үйл ажиллагааны орлогоос, 0.82 төсвийн санхүүжилтээс бүрдүүлж ирсэн байна.

Хүснэгт 3. Шинжлэх ухааны сургуулийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл /2018-2023.06/

	ШУС-НӨГТГЭЛ												
	Үнийн дүн (сая тогроогоор)							Хувийн жин					5 жилийн дундаж
	2023.06	2022	2021	2020	2019	2018	2022	2021	2020	2019	2018		
Монгол хөрөнгийн эхний үлдэгдэл	5,775.90	5,390.92	7,700.73	6,655.49	9,672.41	7,079.45	5,977.15						
I.Төсвийн орлого													
1.Төсвийн санхүүжилт	42.08	766.60	983.75	25.30	42.82	122.19	61.26	3.23	0.10	0.19	0.36	0.23	0.82
Үүнээс: тогтмол зардлын	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЭШ-ний төсөл хөтөлбөр	10.00	718.93	951.67	25.30	42.82	76.25	17.35	3.13	0.10	0.19	0.23	0.07	0.74
Оюутны замын зардлын хөнгөлөлт	32.08	47.67	32.08	-	-	27.98	28.40	0.11	-	-	0.08	0.11	0.06
Хөрөнгө оруулалт	-	-	-	-	-	17.96	15.51	-	-	-	0.05	0.06	0.02
2. Сургалтын төлбөр	19,448.12	7,496.57	17,543.39	19,409.60	14,476.61	18,248.90	15,210.95	57.63	74.27	64.72	54.38	57.31	61.66
Үүнээс: Бакалаврын	17,120.17	6,527.24	15,241.16	17,159.87	12,718.22	15,972.97	13,418.23	50.06	65.66	56.86	47.59	50.55	54.15
Магистрантын	872.18	398.80	945.41	1,175.12	797.76	687.69	645.35	3.11	4.50	3.57	2.05	2.43	3.13
Докторантын	329.30	208.63	381.36	352.75	288.58	383.20	206.71	1.25	1.35	1.29	1.14	0.78	1.16
Гадаад оюутны	1,126.47	361.90	975.46	721.86	672.05	1,205.04	940.66	3.20	2.76	3.00	3.59	3.54	3.22
3.Сургалтын бусад үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.Туслах үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5. Хандив, тусламж	-	0.56	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
6. Үйл ажиллагааны бус орлого	42.50	83.36	59.52	198.60	628.56	263.54	347.17	0.20	0.76	2.81	0.79	1.31	1.17
7. Эрдэм шинжилгээний төсөл	177.36	325.01	515.26	388.56	511.32	775.52	428.67	1.69	1.49	2.29	2.31	1.62	1.88
8.Бусад	-	0.54	10.23	-	-	137.63	84.79	0.03	-	-	0.41	0.32	0.15
3.Дотоод тооцоо	5,778.69	8,227.30	11,330.64	6,111.33	6,707.64	14,012.54	10,409.73	37.22	23.39	29.99	41.75	39.22	34.31
БС, нэгж хоорондын	5,664.94	1,302.04	2,940.44	2,878.69	2,691.33	2,774.31	3,392.75	9.66	11.02	12.03	8.27	12.78	10.75
Салбар сургууль хоорондын	96.85	3,760.35	7,797.70	2,854.04	3,316.83	10,545.35	5,563.28	25.61	10.92	14.83	31.42	20.96	20.75
Захиргаа, төвлөрсөн үйлчилгээний	-	1,740.00	-	-	-	-	258.29	-	-	-	-	0.97	0.19
Хос хавсарга	6.84	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	10.06	1,424.91	592.50	378.60	699.48	692.88	1,195.41	1.95	1.45	3.13	2.06	4.50	2.62
Орлогын бүгд дүн	25,488.75	16,899.94	30,442.79	26,133.39	22,366.95	33,560.32	26,542.57	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00
II.Төсөвлөсөн зардал													-
1. Цалин, шимтгэлийн	21,553.84	12,337.70	17,220.69	14,958.24	13,221.92	12,846.53	11,760.80	52.58	59.62	52.09	41.48	46.23	50.40
2. Бараа үйлчилгээний	1,314.77	306.42	491.40	549.50	895.61	288.42	543.15	1.50	2.19	3.53	0.93	2.13	2.06
3. Сургалтын үйлчилгээ	1,303.21	962.71	1,004.50	818.52	546.92	892.34	808.48	3.07	3.26	2.15	2.88	3.18	2.91
4. Оюутны үйлчилгээ	95.78	73.46	71.72	82.84	71.78	134.14	83.19	0.22	0.33	0.28	0.43	0.33	0.32
5. Эрдэм шинжилгээ	959.55	326.32	687.86	789.24	530.66	568.49	615.33	2.10	3.15	2.09	1.84	2.42	2.32
6. Ашиглалтын тогтмол зардал	257.48	141.35	165.20	153.83	147.51	154.51	-	0.50	0.61	0.58	0.50	-	0.44
7. Хөрөнгийн болон их засвар	371.11	20.36	435.62	541.52	913.49	780.17	479.86	1.33	2.16	3.60	2.52	1.89	2.30
8. Татаас ба урсгал шилжүүлэг	248.56	75.99	215.90	247.09	372.72	247.08	148.02	0.66	0.98	1.47	0.80	0.58	0.90
Үйл ажиллагааны зардлын дүн	26,104.30	14,244.31	20,292.89	18,140.78	16,700.61	15,911.68	14,438.83	61.96	72.31	65.79	51.38	56.76	61.64
7. Хандиваар бэлтгэсэн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8. ЭШП-ийн санхүүжилт	168.74	1,346.39	1,249.62	347.70	742.68	727.86	350.78	3.82	1.39	2.93	2.35	1.38	2.37
3.Дотоод тооцоо	5,926.29	5,517.13	11,210.09	6,599.69	7,940.58	14,327.82	10,650.67	34.23	26.31	31.28	46.27	41.87	35.99
БС, нэгж хоорондын	4,051.80	425.06	1,292.17	967.92	890.37	1,212.75	620.27	3.95	3.86	3.51	3.92	2.44	3.53
Салбар сургууль хоорондын	-	3,356.85	7,810.57	2,854.04	3,316.83	9,325.56	5,054.23	23.85	11.38	13.07	30.11	19.87	19.65
Захиргаа, төвлөрсөн үйлчилгээний	1,800.00	1,260.00	2,000.00	2,417.43	3,418.93	3,625.63	4,419.66	6.11	9.64	13.47	11.71	17.37	11.66
Хос хавсарга	35.60	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	38.89	475.22	107.35	360.30	314.45	163.88	556.51	0.33	1.44	1.24	0.53	2.19	1.14
Зардлын бүгд дүн	32,199.33	21,107.83	32,752.60	25,088.17	25,383.87	30,967.36	25,440.28	100.00	100.00	100.00	100.00	100.00	100.00
Нийт үр дүн (I-II)	(934.68)	1,183.03	5,390.92	7,700.71	6,655.49	9,672.41	7,079.44						

Эх сурвалж: Шинжлэх ухааны сургуулийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаас

Хүснэгт 4. Салбар сургуулиудын төсвийн орлогын бүтэц хувиар

Огноо	НУС				БУС				ХУС				
	Төсвийн санхүү- жилт	Сургалтын төлбөрийн хувь	ЭШ бусад	ЗТС	Төсвийн санхүү- жилт	Сургалтын төлбөрийн хувь	ЭШ бусад	ШУС салбар дэмжлэг	ЗТС	Төсвийн санхүү- жилт	Сургалтын төлбөрийн хувь	ЭШ бусад	ЗТС
2018	0.21	94.32	3.80	1.67		75.15	19.46	11.99	3.78	0.17	95,82	2.33	1,68
2019	0.24	95.56	1.50	2.71	1.05	72.67	14.95	16.12	4.33	0.20	94.16	4.16	1,48
2020		95.55	1.91	2.53	0.66	69.79	20.53	16.03	6.20		96.51	1.32	2,17
2021		97.27	1.88	0.85	0.32	70.20	12.57	24.38	3.04		97.90	1.30	0,80
2022	0.13	97.67	1.62	0.58	9.83	53.34	83.70	26.39	5.57	0.15	99.28	0.09	0,47

Хүснэгт 5. ЭШ, инновацын орлого (мян.төг)

Он	Нийт		Үүнээс: ШУС-ийн багш нар			
	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн тоо	Мөнгөн дүн	Эзлэх хувь	Нэг багшид ногдох орлого
2018	63	2,353.96	41	885.86	37.63	3.7
2019	74	3,184.28	36	1,122.32	35.25	2.9
2020	49	1,303.62	16	311.45	23.89	0.9
2021	104	3,083.27	69	1,714.95	55.62	4.8
2022	118	3,511.38	69	1,891.88	53.88	5.0

Хүснэгт 6. МУИС-ийн дотоод төслөөс авсан санхүүжилт /сая.төгрөгөөр/

Он	Нийт		Үүнээс: ШУС-ийн багш нар			
	Төслийн тоо	Мөнгөн дүн	Төслийн тоо	Мөнгөн дүн	Эзлэх хувь	Нэг багшид ногдох санхүүжилт
2018	23	359.0	16	221.5	61.7	0.92
2019	32	646.0	11	205.8	31.9	0.54
2020	26	552.0	10	216.4	39.2	0.60
2021	23	492.0	13	289.9	58.9	0.80
2022	26	586.3	15	331.0	56.5	0.87
2023	24	530.2	17	351.2	66.2	0.84

2016-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилт;

- сургалтын төлбөр болон улсын төсвөөс бусад орлогын 20-аас доошгүй хувь байхаас 0.1-0.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Улсын төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг зогсоосон байдал;
- хандив, нэрэмжит профессоршип, феллоушип, анги танхим, лаборатори, тоног төхөөрөмж, ном, тэтгэлэг, эндаумент сан зэрэг зорилтот орлогын хэмжээ нь сургалтын төлбөр болон улсын төсвөөс бусад орлогын 30-аас доошгүй хувь байхаас эрдэм шинжилгээ, инновацын дансаар орсон төслийг оруулан тооцоход 2018 онд 11.2 хувь, 2019 онд 8.6%, 2020 онд 9.5%, 2021 онд 9.6%, 2022 онд 9.3%-ийн гүйцэтгэлд ковидын нөхцөл байдал нөлөөлсөн нь зорилт хангагдахгүй байх үндэслэл болжээ.

2.6.2 Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг сүүлийн 5-н жилийн дунджаар харуулбал цалин НДШ-ийн зардал 62.9%, сургалтын үйлчилгээний зардал 3.7%, оюутны үйлчилгээний зардал 0.4%, эрдэм шинжилгээ, төслийн 5.9%, захиргаа төвлөрсөн сангийн үйлчилгээ, бодлогын дэмжлэг 14.5%, бусад бараа үйлчилгээ, ашиглалтын зардал 5.0%, бүрэлдэхүүний сургуулийн импорт 4.5%, хөрөнгийн зардал 2.9%-ийг тус бүр эзэлж байна. Салбар сургууль бүрээр энэ хувь хэмжээ өөр өөр байна.

Хүснэгт 7. Салбар сургуулийн зардлыг бүтэц хувиар

Зардлын зүйл	ШУС	ШУС-НУС	ШУС-БУС	ШУС-ХУС
Цалин, НДШ-ийн зардал	62.9	55.5	67.2	58.9
Сургалтын үйлчилгээний зардал	3.7	2.8	3.9	2.1
ЭШ, төслийн зардал	5.9	2.9	9.7	2.6
Бүрэлдэхүүн сургуулийн импортын үйлчилгээний зардал	4.5	4.6	4.2	4.0
Оюутны үйлчилгээний зардал	0.4	0.3	0.2	0.4
Захиргаа, төвлөрсөн сангийн үйлчилгээ, бодлого төвлөрүүлэлт	14.7	16.9	9.8	17.7
Ашиглалт, бараа үйлчилгээний зардал	5.0	2.9	3.6	2.9
Салбар хоорондын төвлөрүүлэлт		13.5	1.2	11.3
Хөрөнгийн зардал	2.9	0.6	0.2	0.1
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0

Зарлагыг эх үүсвэртэй нь уялдуулан харьцуулан үзвэл үндсэн үйл ажиллагааны орлогын дийлэнх хувийг сургалтын төлбөрийн орлогоор бүрдүүлж байгаа бөгөөд зардлын дийлэнх хувийг цалин, НДШ-ийн зардал эзэлж байна. Цалингийн сангийн гүйцэтгэл жилд дунджаар 9.5 хувь өсөж байхад сургалтын төлбөрийн орлогын гүйцэтгэл 2.9 хувийн бууралттай, өөрөөр хэлбэл цалингийн өсөлтийг орлогын өсөлт гүйцэхгүй байна.

Зураг 4. Сургалтын төлбөрийн орлого болон цалин, НДШ-ийн өсөлтийн харьцаа.



Эх сурвалж: ШУС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд үндэслэн гаргав.

Тухайлбал: Байгалийн ухааны салбар сургууль үндсэн орлого болох сургалтын төлбөрийн орлогынхоо 2018-2019 онуудад 70.0 орчим, 2020-2021 онуудад 93.8-95.9 хувийг цалин, НДШ-д зарцуулж байсан бол 2022 онд тайлант хугацааны орлогоос цалингийн зардал давсан

байна. Байгалийн ухааны салбар сургуулийн үндсэн орлогын дийлэнх хувь цалин, НДШ зарцуулагддаг тул бусад үйл ажиллагааны зардлаа салбар сургуулиудаасаа татаас авч санхүүжүүлж байгааг дээрх орлого болон зарлагын бүтцийн зураглалаас харж болно. Сүүлийн 5 жилийн дунджаар нийт орлогынхоо 12.0-26.0 хувь хүртэл татаас авч нийт зардлынхаа дунджаар 9.8 хувийг санхүүжүүлж ирсэн байна.

Зураг 5. Байгалийн ухааны салбар сургуулийн сургалтын төлбөр цалингийн харьцаа (сая төгрөг)



Хүснэгт 8. Багш, ажилчдын цалин хөлс, нэмэгдлийн төсөв, гүйцэтгэл (сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц	Төсөв	Гүйц
Үндсэн цалин, цол зэрэг	9,541.1	8,727.7	10,059.6	9,578.0	10,983.8	10,683.6	11,574.8	11,081.8	13,736.4	13,119.7
Илүү цаг	476.8	702.0	728.8	803.2	908.2	906.1	906.3	1,204.9	1,392.8	1,117.9
Урамшуулал	498.6	549.5	514.9	428.6	527.8	454.2	541.9	455.9	622.3	570.2
Цагийн хөлс	1,024.8	518.3	813.4	622.1	758.1	502.6	624.0	595.7	523.1	525.1
Дүн	11,541.3	10,497.5	12,116.7	11,432.0	13,177.9	12,546.5	13,647.0	13,338.2	16,274.5	15,332.8
НДШ	1,385.0	1,261.2	1,514.6	1,428.2	1,647.2	1,573.7	1,705.9	1,738.5	2,034.3	1,919.7

ШУС-ийн салбар сургуулиуд цалин, орон тоог төлөвлөхдөө “МУИС-д профессор багш ажиллуулах журмын”-ын 8.3, 8.4-р заалтыг ханган ажиллах зэргээр цалингийн санд хяналт тавихад анхаарах хэрэгтэй байна. <https://www.num.edu.mn/filesnum/juram/NUM-professor-ajilluulah-juram.pdf>


2.6.3 Төсвийн гүйцэтгэлд суурилсан нэг багц цагийн өртөг

Санхүүгийн үр дүнгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлд суурилан багц цагийн өртгийг тооцож харууллаа.

Хүснэгт 9. Төсвийн гүйцэтгэлд суурилсан нэг багц цагийн өртөг /мян.төгрөгөөр/

	ШУС	ШУС-НУС	ШУС-БУС	ШУС-ХУС
2019	130.1	109.9	155.8	124.5
2020	125.3	98.3	161.7	115.8
2021	155.4	124.4	203.3	138.6
2022	172.2	110.9	234.1	171.5

Зураг 6. Төсвийн гүйцэтгэлд суурилсан нэг багц цагийн өртөг



Хүснэгт 10. Орлого үр дүнгийн гүйцэтгэлд суурилсан нэг багц цагийн өртөг /мян.төгрөгөөр/

	ШУС	ШУС-НУС	ШУС-БУС	ШУС-ХУС
2019		159.0	206.0	185.3
2020		97.2	167.9	123.5
2021		101.8	193.6	118.3
2022		125.0	244.4	208.6

Төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн үр дүнд суурилан тооцсон нэг багц цагийн өртөг зардал ялгаатай харагдаж байгаа нь өртөг тооцоход бүтцэд орж буй зарлага болон зардлын зүйл ангиас хамаарч байна. Үүнийг норм нормативт үндэслэн тооцон үйл ажиллагаанд мөрдөж байх шаардлагатай.

2.6.4 2016-2024 оны стратеги төлөвлөгөө болон дунд хугацааны гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлтүүд

ШУС-ийн хөгжлийн ахиц дэвшлийн гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт болон 2016-2024 оны зорилт, завсрын зорилтуудыг тусгайлан дүгнээгүй ч хичээлийн жилийн тайланд дээрх зорилтуудыг хангахад чиглэсэн үйл ажиллагаануудыг дэлгэрэнгүй тайлагнасан байна. 2018-2022 онуудад төсвийн төлөвлөлт нь орцод чиглэсэн эдийн засгийн зүйл заалтаар хийгдсэн хэдий ч сургалтын хөтөлбөрийг үндэсний болон олон улсад магадлуулах, судалгаа, эрдэм шинжилгээг дэмжих, сургалт, судалгааны материаллаг орчин, шаардлага, багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах зэрэгт ач холбогдол өгч ажилласан байна. Цаашид бодлого, үр ашиг, үр дүнд чиглүүлэн нь стратеги төлөвлөгөөний шалгуурыг хангахад хөрөнгө санхүүг оновчтой зохион байгуулах, төлөвлөх, захиран зарцуулах нь зүйтэй.

2.6.5 Нэгж, хоорондын санхүүжилт


Шинжлэх ухааны сургуулийн салбар 3-н сургуулийн бие даасан байдлыг харвал ХУС, НУС нь өөрийн үйл ажиллагаанаас гадна ШУС-аас захиргаа, төвлөрсөн сангийн үйлчилгээ, бодлогод төвлөрүүлэлтэд 10.0-18.0%, Байгалийн ухааны сургуульд 11.3-13.5%-ийн татаасын санхүүжилт хийдэг байна. Байгалийн ухааны салбарт дэмжлэг үзүүлж байгааг харгалзан ШУС-ийн захиргаа, төвлөрсөн сангийн төвлөрүүлэлт сүүлийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байна. МУИС-ийн бүрэлдэхүүний сургуулиуд хөтөлбөр хоорондын экспорт импортын үйлчилгээний тооцоо, тооцоо хийх коэффициент нь санхүүгийн үр дүн тодорхой нөлөө үзүүлдэг байна. БУС нь ХШУИС-д голлох экспортлогч үүрэгтэй бөгөөд бусад сургуулийн сургалт, хөтөлбөрийн төлөвлөгөө нь экспортлогч сургуулиудын хичээл сонголтод нөлөөлж бусад сургуулиас сонгосон багц цаг буурах хандлагатай байна. Экспортлогч сургуулиудын

хувьд энэ хандлага санхүүгийн үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Сургууль хоорондын тооцооны коэффициентыг өнгөрсөн хичээлийн жил шинэчлэн тогтоосон хэдий ч сургууль хоорондын үйлчилгээнд дорвитой өөрчлөлт гараагүй байна. Иймд бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөр хоорондын солилцооны үйлчилгээг бусад бүрэлдэхүүний сургуулиудынхаа үйл ажиллагааны тогтвортой байдлыг дэмжих хэлбэрээр зохион байгуулахад анхаарал хандуулах нь чухал байна. Тухайлбал: Бүх бүрэлдэхүүний сургуулиуд нь гаргах бүтээгдэхүүний сургалтын хөтөлбөрийн загвар гарган түүнд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх.

2.6.6 Элсэлт, шилжилттэй холбоотой

Шинжлэх ухааны сургууль нь нийгмийн ухааны бакалаврын 9, магистрын 11, докторын 10 хөтөлбөрөөр, байгалийн ухааны бакалаврын 22, магистрын 60, докторын 9 хөтөлбөрөөр, хүмүүнлэгийн ухааны бакалаврын 40, магистрын 18, докторын 8 хөтөлбөрөөр элсэлт авч үйл ажиллагаа явуулж байна. МУИС-ийн их сургуулийн Удирдах зөвлөлөөр баталсан хяналтын тоондоо хүргэж элсэлт авч чадахгүй байгааг хичээлийн жилийн тайлангаас харж болохоор байна.¹ Үүнд ЕБС-ийн төгсөгчид, элсэлтийн бодлого журам, хөтөлбөрийн бодлого, журам, элсэлт зохион байгуулах үйл ажиллагаа нөлөөлсөн байна. Шилжилтийн хувьд шилжин ирсэн оюутнаас шилжин явсан оюутны тоо олон байна. Байгалийн ухааны сургуулийн салбарын элсэлт сүүлийн жилүүдэд элсэлтийн хяналтын тоо **38.1%-64.5%**-ийн гүйцэтгэлтэй. Хамгийн ихээр элсэлт тасарч байгаа хөтөлбөртэй сургуулийг жишээ болгон харуулав.

Зураг 7. ШУС-ийн БУС-ийн хяналтын тоо, элсэлтийн байдал



2.6.7 Сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой

Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад сургалтын үйл ажиллагааны журам, хөтөлбөрийн журам, дадлагын журмыг мөрдөж байна. Шинжлэх ухааны Байгалийн ухааны салбар сургуулийн сургалтын зарим хичээл төлөвлөсөн суудлын тоогоор анги дүүргэлт хийгдэхгүй байна. Энэ нь санхүүгийн үр дүнд нөлөөлж байна. Лабораторийн хээрийн дадлагын хичээлийн зардал Удирдах зөвлөлөөс тогтоосон төлбөрөөс өндөр байна. Дадлагын

¹ <https://www.num.edu.mn/portal/activity/yearreport>

зардлын бүтэц ангилал цэгцгүй, дадлагын хичээл бүрд өөр өөр зардал олгож байна. Дадлагын журам болон сургалтын үйл ажиллагааны журмын хоорондын зөрүүтэй байдлыг арилгах, үндэслэлгүй заалтуудаар хөлс тооцох зэрэг асуудлууд байна.

2.6.8 2023 оны эхний хагас улирлын төсвийн гүйцэтгэл

ШУС-ийн 2023 оны эхний хагас улирлын нэгдсэн төсвийн төсөвлөсөн орлого 11.4 тэрбум төгрөг буюу 45.0%-ийн, төсөвлөсөн зарлага нь 21.1 тэрбум төгрөг буюу 65.5%-ийн гүйцэтгэлтэй байна. *Дэлгэрэнгүй тайланг Хавсралт 2-оос харна уу.*

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл төсөвлөсөн дүнгээс 7.1 хувиар буурсан байна. Энэ нь Захиргаа төвлөрсөн сан боловсролын зээлийн сан, ерөнхийлөгчийн илгээлтийн мөнгийг 2022 оны сүүлээр шилжүүлнэ гэж мөнгөний эхний үлдэгдэлд төлөвлүүлээд ондоо шилжүүлээгүй 2023 онд шилжсэнтэй холбоотой байна.

Сургалтын төлбөрийн орлого нь харилцахаар орж ирсэн орлогын тооцоогоор төлөвлөгөө 88.1%-ийн гүйцэтгэлтэй байгаа ч ХУС, НУС-ын орлого хичээл сонголтоор биелэхээр төлөвтэй байна. Орлогод БЗС, төсвийн санхүүжилт, элсэлт бүртгэлийн хураамж, гадаад оюутны сургалтын төлбөр, засгийн газрын гэрээний санхүүжилт, ерөнхий суурийн хичээлийн сургууль хоорондын тооцоо бүрэн хийгдээгүй байгаа нь нөлөөлсөн байна.

Сургалтаас бусад орлого нь 2023 оны хагас улирлын тайлангаар 189.0 сая төгрөгөөр давсан байна.

Төсвийн санхүүжилтийн орлого нь 724.5 сая төгрөгөөр давж орсон байна. Үүний 708.9 сая төгрөг нь физикийн олимпиад, 15.6 сая төгрөг нь оюутны замын зардлын хөнгөлөлтийн байна.

Төсвийн зарлагын цалин НДШ 57.2%, сургалтын үйлчилгээ 73.9%, оюутны үйлчилгээ 76.7%, ашиглалтын зардал 54.9%, эрдэм шинжилгээ 34.%, хөрөнгийн болон их засвар 5.5% байна. Гадаад эх үүсвэрээр санхүүжих төсөл хөтөлбөрийн зардлууд давсан байгаа олимпиад, ерөнхийлөгчийн илгээлтийн зардлуудтай холбоотой байна. Зуны борооны улирлаар хичээлийн байруудад ус орсонтой холбогдуулан урсгал засварт 32.0 сая, дадлагын баазын газрын төлбөрт 1.7 сая төгрөгийн төсөвт тусгагдаагүй төгрөгийн зарцуулалт хийгдсэн байна. 2023 оны төсвийн тодотгол хийх талаар бүрэлдэхүүний сургуулиас санал аваагүй тул давсан орлоо, зарлагыг төсвийн тодотголд оруулж чадаагүй байна. Захиргаа, төвлөрсөн сангаас ХУС 1000.0 сая, БУС 740.0 сая төгрөгийг, салбар сургуулиудаасаа БУС 860.0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа санхүүжүүлсэн байна.

2.6.8 МУИС-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийн мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг шинэчлэн батлуулах зөвлөмжийн хүрээнд: - МУИС-ийн НБББББ-ийг шинэчлэн батлуулаагүй байгаа тул одоо хэрэглэж байгаа баримт бичгийн дагуу бүртгэл хийгдэж байна.

Санхүүгийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж батлуулах зөвлөмжийн хүрээнд: - МУИС-ийн санхүүгийн журмыг шинэчлэгдээгүй байна.

Төсөв, НББ-ийн программыг нэвтрүүлж дуусгах зөвлөмжийн хүрээнд - Төсвийн программ 95%-тай нэмэлт модулийн хөгжүүлэлт хийгдээгүй, санхүүгийн программ ашиглалтад ороогүй, хагас улирлын тайлан нэгтгэл хуучин программаар хийгдсэн, шинэ программд өмнөх оны эхний ҮХ, БМ, авлага, өглөгийн өгөгдлүүд, эхний үлдэгдлүүд бүрэн орсон, Сиси-ийн (сургалтын төлбөрийн орлого) -интеграци хийгдсэн боловч тайлангуудыг гарган өгч чадахгүй байна.

Шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийн хүрээнд: - ШУС-захиргаа орлого 1, зарлага 5 гүйлгээ, ШУС-НУС орлого 1, зарлага 2 гүйлгээ, ШУС-БУС орлого 2, зарлага 3 гүйлгээ, ШУС-ХУС орлого 1, зарлага 10 гүйлгээг байршуулаагүй байна. Өмнөх аудитын дүгнэлтээр гарсан цалин, НДШ-тэй холбоотой зөрчлийг арилгаж ажилласан байна. МУИС-ийн төв санхүүгээс шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Төсөв, санхүүгийн ажилтан нарыг мэргэжлийн болон хуулийн өөрчлөлтүүдийн сургалт, семинарт хамруулах зөвлөмжийн хүрээнд: - ТӨИДС-уудын дунд хийсэн хэлэлцүүлэгт санхүүгийн ажилтнууд хамрагдсан байна.

Дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийн хүрээнд: - ШУС-ийн захирлын тушаалаар бүх зарцуулалтын гүйлгээ хийгдэж байгаа нь сайшаалтай байна. Түүнээс гадна бүх шатандаа дотоод хяналтыг тавих, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд цахимаар хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх үүднээс программыг яаралтай ашиглалтад оруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон МУИС-ийн захирлын 2023.04.14-ны А/159 тоот тушаалаар хориглосон зардлын хэрэгжилт - Харилцах болон бэлэн мөнгөөр хийгдсэн ажил гүйлгээг захирлын тушаалыг үндэслэн БАҮАДЗ, ЭШИ, сургалтын үйлчилгээ, төлбөр хураамж гадаад албан томилолтын зардлыг түүвэрлэн тулган баталгаажуулах горим гүйцэтгэсэн. Холбогдох асуудалд зөвлөмж өглөө. *Хүснэгт 11. Шинжлэх ухааны сургуулийн 2023 оны эхний хагас улирлын төсвийн гүйцэтгэлтэй холбоотой зарим асуудалд өгсөн зөвлөмж -өөс харах*

Бусад холбогдох дүрэм журмын хэрэгжилт: - Сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, Суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэрэг эрх зүйн актуудаас гадна МУИС-ийн дотоод дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Сургуулийн удирдлага, санхүүгийн ажилтнуудын санхүүгийн холбогдолтой хууль эрх зүй акт, журам, түүнд холбогдох тайлан мэдээнүүдийн талаарх ойлголт, программ хангамжийн ашиглалт харилцан адилгүй өөр өөр байна.

2.6.9 Төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл явц

Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн тайланг нэгж бүрээр нь МУИС-ийн нэгдсэн тайланд нэгтгэж байгаа нь удирдлагын шийдвэр гаргалтын мэдээллийг бодитой илэрхийлэхэд эрсдэл үүсгэж байна. ШУС-ийн тайланг нэгтгэж МУИС-ийн нэгдсэн тайланд тайлагнах замаар нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, төсөвлөсөн нэгж, төсөвлөсөн сууриар тайлагнах шаардлагатай байна.

2.6.10 Санхүүгийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх

СЭЗБГ-аас үйл ажиллагааг удирдан чиглүүлж тодорхой мэргэжлийн удирдамж, бодлого, журмаар хангах ажил зарим талаараа хангалтгүй байна. Шийдвэр гаргалт, удирдлагын мэдээллийн ач холбогдол, үнэ цэнтэй байдлыг хангах, орон тоог бүрэн бүрэлдэхүүнээр ажиллуулахад анхаарах шаардлагатай байна.

ХОЁР. ДҮГНЭЛТ

1. Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн тогтворжилтын хувьд үзүүлэлтүүд нь өмнөх онуудтай харьцуулбал буурсан боловч төсвийн санхүүжилт болон бусад гадаад эх үүсвэрээс хараат бусаар үндсэн ажиллагааны орлогоороо урсгал зардал төдийгүй хөрөнгө оруулалтын хэсгийг санхүүжүүлж тогтвортой байсан ч 2020 оноос эхлэн санхүүгийн үр дүн сөрөг дүнтэй болжээ. Энэ нь хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд: орлого талаас 1) МУИС-ийн УЗ-өөс тогтоосон сургалтыг төлбөр нь санхүүгийн болон үр дүнгийн гүйцэтгэлд суурилсан өртөг зардлаас доогуур ба 2018 оноос 2023

он хүртэл нэмэгдээгүй тогтмол 2) Ковидын нөхцөл байдал 3) Ашиглалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй болсон 4) Элсэлтийг хяналтын тоондоо хүргэж авч чадахгүй байгаа байдал;

- зарлага талаас 1) Цалингийн өсөлтийг сургалтын орлогын өсөлт гүйцэхгүй зэрэг нөлөөлсөн гэж үзлээ.
- 2. Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн эх үүсвэр 2018 онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл **6 дахин** буурсан, үндсэн хөрөнгө **73.8** хувийн элэгдэлтэй байгаа нь эх үүсвэр хумигдсаныг илтгэж байна.
- 3. ШУС-ийн эрдэмтэд судлаачид 2018-2023 онуудад МУИС-ийн ЭШИ-ын төслийн 23.9-53.9%-ийн орлогыг бүрдүүлдэг байна. Харин МУИС-аас нийт дотоод санхүүжилтээс дунджаар 60.0 орчим хувийг авч судалгааны ажил гүйцэтгэж байна.
- 4. Шинжлэх ухааны сургууль нь Байгалын ухааны салбар сургуулийнхаа үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд захиргаа, төвлөрсөн үйлчилгээний зардлаас чөлөөлөн 2018-2023 он эхний хагас хүртэл ХУС болон НУС-аас нийтдээ 7497.4 сая төгрөгийн татаасыг авч санхүүжүүлжээ. 2023 оны эхний хагас улирлын тайлангаар ХУС, БУС нь эх үүсвэрийн дутагдалд орж Захиргаа төвлөрсөн сангаас 1.7 тэрбум төгрөгийг зээл авч илүү цаг, ээлжийн амралтын хөлсөө олгосон байна.
- 5. Шинжлэх ухааны сургуулийн нийт багшийнх нь 23.1%, үүнээс 63.4% нь докторын зэрэгтэй, нийт идэвхтэй суралцагчдын 40% хамрагддаг Нийгмийн ухааны салбарын санхүүгийн үйл ажиллагаа харьцангуй тогтвортой байна гэж үзлээ. Харин Хүмүүнлэгийн ухааны салбарт нийт багшийнх нь 43.8%, үүнээс 54.1% нь докторын зэрэгтэй, нийт идэвхтэй суралцагчдын 36.2% хамрагддаг байна. Хүмүүнлэгийн ухааны салбарын 2023 эхний хагас улирлын сургалтын төлбөрийн орлогын биелэлт 38.9 хувийн гүйцэтгэлтэй байгаатай холбоотойгоор санхүүгийн тогтворгүй байдал үүссэн байна. ХУС-ийн хичээл сонголтын гүйцэтгэлээр орлого биелэх боломжтой байгаа тул нэгж хоорондын дотоод тооцоо судалгаа, үйл ажиллагаа зохион байгуулалтаа сайжруулснаар тайлант онд санхүүгийн байдал тогтворжих боломж байна гэж үзлээ. Өмнөх онуудад БУС-т үзүүлж байсан дэмжлэгийн дийлэнх хувь тус салбарт хамрагдаж байсан. ХУС нь эхний хагас улирлаар ЗТС-аас зээл авсан болон УБС-аас оюутангүй 25 багш ирсэн зэргээс одоогийн нөхцөл байдлаар БУС-т дэмжлэг үзүүлж чадахааргүй болсон байна.
- 6. БУС-ийн хувьд Шинжлэх ухааны сургуулийн нийт багшийн 33.1%, үүнээс докторын зэрэгтэй 82.8%, идэвхтэй суралцагчдын 23.8% хамаарагддаг. Санхүүгийн байдал тогтворгүй байна. Өмнөх жилүүдэд тайлант оныхоо орлогын 12.0-26.0 хувь хүртэл татаас авч бүрдүүлж байсан бол 2023 оны байдлаар цалин өссөнөөр бусад салбарууд нь татаас өгөх боломжгүй болжээ. Зөвхөн цалин, НДШ нь үндсэн үйл ажиллагааны гол хувь хэмжээг эзэлдэг сургалтын төлбөрийн орлогоос хол давсан байна. 2023 оны эхний хагас улирлаар сургалтын төлбөрийн орлого 39.5%-иар биелсэн үүн дээр энэ намрын хичээл сонголтыг оруулан тооцвол 80% орчим хувийн биелэхээр төлөвтэй байна. Энэ нь төлөвлөсөн цалингийн зардлын 61.0% орчим хувийг хангахаар байна. Сүүлийн жилүүдэд элсэлтийг хяналтын тоондоо хүргэн авч чадахгүй 38.1%-64.5%-ийн гүйцэтгэлтэй байгаа байдал ч нөлөөлсөн байна.
- 7. ШУС-аас сургалтын үр дүнтэй зохион байгуулах, багшийн цагийн ногдлын хяналтыг сайжруулах, илүү цаг олгохгүй байх зэрэг арга хэмжээнүүдийг авч байгаа хэдий ч нэгдсэн бодлого, журамтай бүрэлдэхүүний сургууль учраас сургуулийн бодлогоос ангид байх нөхцөл боломж бүрдээгүй байна.
- 8. БУС-ийн санхүүгийн тогтворгүй байдал үүсэхэд элсэлт, цалингийн өсөлтөөс гадна сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалт нь үр дүнд нөлөөлж байна. Иймд түүнд холбогдох хөтөлбөр, элсэлтийн журам, дадлагын журам, МУИС-д профессор

ажиллуулах журам, сургалтын төлбөр тогтоох үндэслэлийг анхааран бодлогоор тусгайлан зохицуулалт хийх шаардлага байна гэж үзлээ. Зах зээлийн нийлүүлэлтээс хамаарсан орон, тоо бүтцийн зураглал гаргах өөрөөр хэлбэл нийт ногдлын хэдэн хувийг үндсэн багшаар, хэдэн хувийг цагийн багшаар заалгах, нийлүүлэлт багассан үед энэ харьцаа ямар байх зэрэг бодлого, бодлоготой уялдсан уян хатан төсвийн төлөвлөлт зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

9. МУИС-ийн цалингийн өсөлтийг орлогын өсөлт нь гүйцэхгүй байна. Цалингийн сангийн гүйцэтгэл жилд дунджаар 9.5 хувь өсөж байхад сургалтын төлбөрийн орлогын гүйцэтгэл 2.9 хувийн бууралттай байна. Үүний үр дүнд хамгийн их сөрөг нөлөөлөл авсан Байгалийн ухааны салбар сургууль байна. БУС-ын цалин, НДШ сургалтын төлбөрийн орлогынхоо 2018-2019 онуудад 70.0 орчим, 2020-2021 онуудад 93.8-95.9 хувь байна.
10. Нэг багц цагийн өртөг зардал Удирдах зөвлөлөөр тогтоосон төлбөрийн өсөлтөөс доогуур байгаа нь орлого буурахад гол нөлөө үзүүлж байна.
11. ШУС-ийн 2023 оны төсвийн хэрэгжилтийн урьдчилсан төлөвөөр орлого төлөвлөсөн хэмжээнд орохгүй байх төлөвтэй байгаа тул орлого орж баталгаажсанаар зарцуулалтыг хийх зэргээр төсвийн хэмнэлттэй, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь шаардлагатай.
12. МУИС-ийн санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн захирал болон СЭЗБГ-аас үйл ажиллагааг удирдан чиглүүлж тодорхой мэргэжлийн удирдамж, бодлого, журмаар хангах талаар ҮАГ-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллахгүй бол энэ нь бүрэлдэхүүний сургуулиудад эрсдэл үүсгэж болзошгүй байна.
13. СЭЗБГ-аас шийдвэр гаргалт, удирдлагын мэдээллийн ач холбогдол, үнэ цэнтэй байдлыг хангах, орон тоог бүрэн бүрэлдэхүүнээр ажиллуулахад анхаарахгүй байгаа нь санхүүгийн үйл ажиллагаа, зохион байгуулалт үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

ГУРАВ. 2023 ОНЫ САНХҮҮТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Сургуулийн захирал, салбарын захирал, ахлах нягтлан бодогч нартай уулзалт зохион байгуулан аудитын урьдчилсан үр дүнг танилцуулан санал нэгтгэн дараах зөвлөмжийг өгч ажиллаа.

Хүснэгт 11. Шинжлэх ухааны сургуулийн 2023 оны эхний хагас улирлын төсвийн гүйцэтгэлтэй холбоотой зарим асуудалд өгсөн зөвлөмж

Д.д	Эдийн засгийн ангилал	Мөнгөн дүн сая.төг	Тайлбар, зөвлөмж
1.	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	(1,786.4)	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл төсөвлөсөн дүнгээс 1.7 тэрбум төгрөгөөр буурсан байгаа нь ЗТС-тай хийх тооцоотой холбоотой байн. Жилийн эцсийн тайлант хугацаа, төсөв хийхээс өмнө сургууль, нэгжүүд хоорондоо тооцоогоо нийлж өглөг, авлагаа бүрэн дуусгаж байх зөвлөмж өгсөн.
2.	ХУС орлогын гүйцэтгэл		Хичээл сонголтод тулгуурлан сургууль, нэгжүүд хоорондоо тооцоогоо нийлэн өглөг, авлагаа бүрэн дуусган орлогын төлөвөө урьдчилан харах;
2.	Физикийн олимпиадын төслийн орлого	718.9	Төсвийн (орлого, зарлага)-д тодотгол хийлгэх талаар МУИС-ийн захиргаанд санал хүргүүлэх зөвлөмж өгсөн.

3.	Ерөнхийлөгчийн илгээлт	853.09	Төсвийн (мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, орлого, зарлага)-д тодотгол хийлгэх талаар МУИС-ийн захиргаанд санал хүргүүлэх зөвлөмж өгсөн.
4.	Хичээл практикийн зардал	7.0	Ангилал зөрсөн төсөвлөсөн сууриар тайлагнах
5.	Багш ажилчдад үзүүлэх дэмжлэг	3.1	Номын сангийн ажилчдад туршлага солилцох зардал олгосон. Бүтцэд байхгүй нэгжийн ажилчдад зардал гаргахгүй байх
6.	Урсгал засвар	32.0	Төсвийн (зарлага)-д тодотгол хийлгэх талаар МУИС-ийн захиргаанд санал хүргүүлэх зөвлөмж өгсөн.

ДӨРӨВ. ЦААШИД ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

МУИС-ийн хэмжээнд

1. Шинжлэх ухааны сургуулийн Байгалийн ухааны салбарт санхүүгийн тогтвортой байдал алдагдахад нөлөөлж буй бодлого, журам, үйл ажиллагааны асуудлыг нарийвчлан судалж бодлогоор дэмжихэд анхаарах;
2. Эрэлт нийлүүлэлтэд тулгуурласан хөтөлбөр, элсэлт, хүний нөөц, санхүү төсвийн уян бодлого хэрэгжүүлэх;
3. Бодлогын өртөг (policy costing) тооцдог байх;
4. Бүрэлдэхүүний сургуулиудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх мэргэжлийн бодлого, журмаар хангах;
5. Бүрэлдэхүүний сургуулиудын санхүүгийн эрх үүрэг, хариуцлагын механизмыг боловсронгуй болгох, эрх зүйн актаар баталгаажуулах;
6. МУИС-ийн сургалтын төлбөрийг өртөг зардлыг нөхөх хэмжээнд тогтоолгоход;
7. Нөөцийн хуваарилалтыг зохистой хийх, менежментийг сайжруулахад (төсвийн төсөлд эрсдэлийг харгалзан үзэх, төсөл арга хэмжээний өртөг, үр өгөөжийг бодитоор тооцоолон зардлын үр ашигтай байдал ба зайлшгүй эрэмбийн зарчмаар хуримтлагдсан мөнгөн хөрөнгийн урсгалыг зөв байршуулан удирдан чиглүүлэх);
8. Бүрэлдэхүүн хоорондын экспорт, импортын үйлчилгээг бодлогоор зохицуулалт хийхэд анхаарах.

ШУС-ийн хэмжээнд

1. Сургалтын үйл ажиллагааг үр ашигтай хэлбэрээр зохион байгуулах;
2. Сургалтын төлбөрөөс бусад орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарах;
3. Судалгаа, эрдэм шинжилгээний эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлэх;
4. Хөрөнгө санхүүг бодлого, үр ашиг, үр дүнд чиглүүлэн нь стратеги төлөвлөгөөний шалгуурыг хангахад оновчтой зохион байгуулах, төлөвлөх, захиран зарцуулах нь
5. Дотоод хяналтыг бүх түвшинд сайжруулах.

Санхүүгийн бодлогын газрын хэмжээнд

1. Санхүүгийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж тодорхой мэргэжлийн журам, гарын авлага, удирдамжаар хангах;
2. НББ-ийн суурийг сайжруулах, төсөв, төсвийн гүйцэтгэлийн суурийг ижил болгож, зөв тайлагнах (төсөвлөсөн сууриараа бүртгэж тайлагнах, мөнгөн гүйлгээний тайлангийн тохируулга, ямар зохицуулалт хийхийг бодлогын бичиг баримтад тусган шийдвэрлэх)

3. Төсөв, санхүүгийн шууд захирагч нарт чиглүүлэх үйлчилгээ үзүүлэх;
4. Санхүүгийн ажилтнууд буюу ахлах албан тушаалд ажиллаж байгаа ажилтнуудын мэргэшсэн байдалд анхаарах;
5. Орон тоог бүрэн бүрэлдэхүүнээр ажиллуулах;
6. ҮАГ-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, түүнд дотоод хяналт тавих;
7. Санхүүгийн программ хангамжийг яаралтай ашиглалтад оруулах;
8. Төсвийн гүйцэтгэлийг цахимаар хянах нөхцөл төсвийн шууд захирагч нарт бүрдүүлэх.

Шинжлэх ухааны сургуулийн санхүүгийн хэмжээнд

1. Сургууль, нэгж, хоорондын тооцоогоо цаг тухайд хийж өр авлагаа барагдуулж байх;
2. Санхүүгийн үйл ажиллагаандаа шинжилгээ хийж удирдлагыг мэдээллээр хангахад мэргэжлийн дэмжлэг үзүүлж байх;
3. Удирдлагын шийдвэр гаргалтын мэдээллийн ач холбогдол, үнэ цэнтэй байдлыг хангах;
4. Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсөвлөсөн сууриар гаргадаг байх.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР: Д.ТУНГАЛАГ

ТАНИЛЦСАН:

ШУС-ИЙН ЗАХИРАЛ: Д.ЗАЯАБААТАР

ШУС-НУС-ЫН ЗАХИРАЛ Д.ТАМИР

ШУС-БУС-ЫН ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭЦОГТ

ШУС-ХУС-ЫН ЗАХИРАЛ Н.АЛТАНТӨГС

АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ Б.МӨНГӨН-ОД

..... А.ТУЯАЦАЦРАЛ

..... Д.МӨНХТУЯА

"МУИС-ИЙН ШУС-ИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (2018-2023.06 он)										Хавсралт 1				
№	Утга	Балансын үлдэгдэл (сая.төг)					Хувийн жин					5 жилийн дундаж		
		2023.06	2022	2021	2020	2019	2018	2023.06	2022	2021	2020		2019	2018
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ														
1.1	Мөнгө	1,183.01	5,390.90	7,700.70	6,655.50	9,672.40	7,079.46	17.8	49.9	55.5	46.5	64.3	53.9	54.02
1.2	Авлага ба бусад тооцоо	719.91	755.10	1,423.10	2,723.80	241.20	634.05	10.8	7.0	10.3	19.0	1.6	4.8	8.54
	Үүнээс: төлбөрийн авлага	712.18	745.60	1,374.90	783.10	219.90	288.33	10.7	6.9	9.9	5.5	1.5	2.2	5.19
1.3	Бараа материалын нөөц	934.30	807.10	709.60	604.90	502.80	467.99	14.0	7.5	5.1	4.2	3.3	3.6	4.74
	Үүнээс: хангамжийн материал	494.98	807.10	709.60	604.90	502.80	184.77	7.4	7.5	5.1	4.2	3.3	1.4	4.31
	түүхий эд материал	-					-	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
	мал амьтад	-					-	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	-
1.4	Урьдчилж гарсан зардал, тооцоо	49.37	18.10	105.50	13.50	39.60	37.02	0.7	0.2	0.8	0.1	0.3	0.3	0.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,886.59	6,971.20	9,938.90	9,997.70	10,456.00	8,218.52	43.3	64.5	71.7	69.9	69.5	62.6	67.62
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ														
2.1	Үндсэн хөрөнгө	14,500.95	14,130.50	13,165.10	12,331.40	11,659.50	10,941.00	217.6	130.7	94.9	86.2	77.5	83.3	94.53
	Хуримтлагдсан элэгдэл	(10,726.74)	(10,297.80)	(9,249.50)	(8,041.30)	(7,119.26)	(6,075.10)	-161.0	-95.3	-66.7	-56.2	-47.3	-46.2	(62.35)
	ҮХ-ийн цэвэр дүн	3,774.21	3,832.70	3,915.60	4,290.10	4,540.24	4,865.90	56.6	35.5	28.2	30.0	30.2	37.0	32.18
	Үүнээс: Барилга	377.64	377.6					5.7	3.5	0.0	0.0	0.0	0.0	0.70
	Сургалтын машин, т/т	11,335.90	11048.8	10,614.70	9,811.10	9,283.40	8,692.94	170.1	102.2	76.5	68.6	61.7	66.2	75.05
	Тавилга, хэрэгсэл	2,014.00	1955.1	1,850.70	1,859.90	1,731.40	1,700.00	30.2	18.1	13.3	13.0	11.5	12.9	13.78
	Номын фонд	690.70	665.5	635.10	595.90	580.20	547.27	10.4	6.2	4.6	4.2	3.9	4.2	4.59
2.2	Нийтийн тохижилт, бусад	82.71	83.5	64.60	64.50	64.50	0.79	1.2	0.8	0.5	0.5	0.4	0.0	0.42
2.3	Биет бус хөрөнгүүд	2.06	4.1	12.00	23.60	44.40	51.70	0.0	0.0	0.1	0.2	0.3	0.4	0.20
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,776.27	3,836.80	3,927.60	4,313.70	4,584.64	4,917.60	56.7	35.5	28.3	30.1	30.5	37.4	32.38
	Нийт хөрөнгийн дүн	6,662.86	10,808.00	13,866.50	14,311.40	15,040.64	13,136.12	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
3. ӨР ТӨЛБӨР														
3.1.	Бараа үйлчилгээний өглөг	21.98		4.20			2.75	0.3	-	0.0	-	-	0.0	0.01
3.2.	Ажиллагчдад өгөх өглөг	-		1.30		0.08	1.06	-	-	0.0	-	0.0	0.0	0.00
3.3.	Бусад	10.64				1.10	0.88	0.2	-	-	-	0.0	0.0	0.00
3.4	Урьдчилж орсон орлого	2,759.25	3,072.30	1,883.20	1,657.80	1,257.10	1,320.83	41.4	28.4	13.6	11.6	8.4	10.1	14.40
	БХӨ-ийн дүн	2,791.87	3,072.30	1,888.70	1,657.80	1,258.28	1,325.52	41.9	28.43	13.62	11.58	8.37	10.09	14.42
	Ург хугацаатай өр төлбөр				-		-	-	-	-	-	-	-	-
	Нийт өр төлбөрийн дүн	2,791.87	3,072.30	1,888.70	1,657.80	1,258.28	1,325.52	41.9	28.43	13.62	11.58	8.37	10.09	14.42
4. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ														
4.1	Засгийн газрын оролцоо	3,512.17	3,512.20	3,345.10	3,345.10	3,345.13	3,345.13	52.7	32.5	24.1	23.4	22.2	25.5	25.54
4.2	Хуримтлагдсан үр дүн	304.20	4,168.90	8,632.70	9,308.50	10,437.23	8,465.47	4.6	38.6	62.3	65.0	69.4	64.4	59.94
	Үүнээс: тайлант оны	(3,864.70)	(4,461.70)	(681.80)	(1,128.70)	1,971.76	1,428.41	(58.0)	(41.3)	(4.9)	(7.9)	13.1	10.9	(6.02)
	Өмнөх үеийн	4,168.90	8,630.60	9,314.50	10,437.20	8,465.47	7,037.06	62.6	79.9	67.2	72.9	56.3	53.6	65.96
4.3	Дахин үнэлгээний нөөц	54.62	54.60					0.8	0.5	-	-	-	-	0.10
	Өмчийн дүн	3,870.99	7,735.70	11,977.80	12,653.60	13,782.36	11,810.60	58.1	71.57	86.38	88.42	91.63	89.91	85.58
	Өр төлбөр ба өмчийн дүн	6,662.86	10,808.00	13,866.50	14,311.40	15,040.64	13,136.12	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

	ШУС-НЭГТГЭЛ											
	Үнийн дүн (сая төгрөгөөр)							Хувийн жин				
	2023.06		2022	2021	2020	2019	2018	2022	2021	2020	2019	2018
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	5,775.90	5,390.92	7,700.73	6,655.49	9,672.41	7,079.45	5,977.15					
I.Төсвийн орлого												
1.Төсвийн санхүүжилт	42.08	766.60	983.75	25.30	42.82	122.19	61.26	3.05	0.09	0.19	0.35	0.22
Үүнээс: тогтмол зардлын	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЭШ-ний төсөл хөтөлбөр	10.00	718.93	951.67	25.30	42.82	76.25	17.35	2.95	0.09	0.19	0.22	0.06
Оюутны замын зардлын хөнгөлөлт	32.08	47.67	32.08	-	-	27.98	28.40	0.10	-	-	0.08	0.10
Хөрөнгө оруулалт	-	-	-	-	-	17.96	15.51	-	-	-	0.05	0.06
2. Сургалтын төлбөр	19,448.12	7,496.57	17,543.39	19,409.60	14,476.61	18,248.90	15,210.95	54.37	69.70	63.83	52.62	55.46
Үүнээс: Бакалврын	17,120.17	6,527.24	15,241.16	17,159.87	12,718.22	15,972.97	13,418.23	47.24	61.62	56.08	46.05	48.92
Магистрантын	872.18	398.80	945.41	1,175.12	797.76	687.69	645.35	2.93	4.22	3.52	1.98	2.35
Докторантын	329.30	208.63	381.36	352.75	288.58	383.20	206.71	1.18	1.27	1.27	1.10	0.75
Гадаад оюутны	1,126.47	361.90	975.46	721.86	672.05	1,205.04	940.66	3.02	2.59	2.96	3.47	3.43
3.Сургалтын бусад үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.Туслах үйлчилгээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5. Хандив, тусламж	-	0.56	-	-	-	-	-	-	-	-	-	-
6. Үйл ажиллагааны бус орлого	42.50	83.36	59.52	198.60	628.56	263.54	347.17	0.18	0.71	2.77	0.76	1.27
7. Эрдэм шинжилгээний төсөл	177.36	325.01	2,337.16	2,103.56	822.82	1,897.82	1,314.57	7.24	7.55	3.63	5.47	4.79
8.Бусад	-	0.54	10.23	-	-	137.63	84.79	0.03	-	-	0.40	0.31
3.Дотоод тооцоо	5,778.69	8,227.30	11,330.64	6,111.33	6,707.64	14,012.54	10,409.73	35.12	21.95	29.58	40.40	37.95
БС, нэгж хоорондын	5,664.94	1,302.04	2,940.44	2,878.69	2,691.33	2,838.61	3,392.75	9.11	10.34	11.87	8.18	12.37
Салбар сургууль хоорондын	96.85	3,760.35	7,797.70	2,854.04	3,316.83	10,491.02	5,563.28	24.17	10.25	14.63	30.25	20.28
Захиргаа, төвлөрсөн үйлчилгээний	-	1,740.00	-	-	-	-	946.75	-	-	-	-	3.45
Хос хавсарга	6.84	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	10.06	1,424.91	592.50	378.60	699.48	682.91	506.95	1.84	1.36	3.08	1.97	1.85
Орлогын бүгд дүн	25,488.75	16,899.94	32,264.69	27,848.39	22,678.45	34,682.62	27,428.47	100.00	100.00	100.00	100.00	100.00
II.Төсөвлөсөн зардал												
1. Цалин, шимтгэлийн	21,553.84	12,337.70	17,220.69	14,958.24	13,221.92	12,846.53	11,760.80	69.04	67.28	59.92	59.30	59.14
2. Бараа үйлчилгээний	1,314.77	306.42	491.40	549.50	895.61	288.42	543.15	1.97	2.47	4.06	1.33	2.73
3. Сургалтын үйлчилгээ	1,303.21	962.71	1,004.50	818.52	546.92	892.34	808.48	4.03	3.68	2.48	4.12	4.07
4. Оюутны үйлчилгээ	95.78	73.46	71.72	82.84	71.78	134.14	83.19	0.29	0.37	0.33	0.62	0.42
5. Эрдэм шинжилгээ	959.55	326.32	687.86	789.24	530.66	568.49	615.33	2.76	3.55	2.40	2.62	3.09
6. Ашиглалтын тогтмол зардал	257.48	141.35	165.20	153.83	147.51	154.51	-	0.66	0.69	0.67	0.71	-
7. Хөрөнгийн болон их засвар	371.11	20.36	435.62	541.52	913.49	780.17	479.86	1.75	2.44	4.14	3.60	2.41
8. Татаас ба урсгал шилжүүлэг	248.56	75.99	215.90	247.09	372.72	247.08	148.02	0.87	1.11	1.69	1.14	0.74
Үйл ажиллагааны зардлын дүн	26,104.30	14,244.31	20,292.89	18,140.78	16,700.61	15,911.68	14,438.83	81.36	81.59	75.68	73.45	72.61
7. Хандиваар бэлтгэсэн хөрөнгө	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8. ЭШТ-ийн санхүүжилт	168.74	1,346.39	1,249.62	347.70	742.68	727.86	350.78	5.01	1.56	3.37	3.36	1.76
3.Дотоод тооцоо	5,926.29	5,517.13	11,210.09	6,599.69	7,940.58	14,327.82	10,650.67	13.63	16.85	20.95	23.19	25.63
БС, нэгж хоорондын	4,051.80	625.06	1,292.17	967.92	890.37	1,212.75	620.27	5.18	4.35	4.03	5.60	3.12
Салбар сургууль хоорондын	-	3,156.85	7,810.57	2,854.04	3,316.83	9,304.86	5,554.23					
Захиргаа, төвлөрсөн үйлчилгээний	1,800.00	1,260.00	2,000.00	2,417.43	3,418.93	3,625.63	4,419.66	8.02	10.87	15.49	16.74	22.22
Хос хавсарга	35.60	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бусад	38.89	475.22	107.35	360.30	314.45	184.58	56.51	0.43	1.62	1.42	0.85	0.28
Зардлын бүгд дүн	32,199.33	21,107.83	32,752.60	25,088.17	25,383.87	30,967.36	25,440.28	100.00	100.00	100.00	100.00	100.00

Шинжлэх ухааны сургуулийн бүрэлдэхүүний санхүүгийн байдлын тайлан
(2018-2023.06 он)

Хавсралт 3

Хөрөнгийн төрөл		2023.06	2022	2021	2020	2019	2018
ШУС захиргаа	2.1 Үндсэн хөрөнгө	464.38	464.00	289.30	132.41	68.93	68.17
	Хуримтлагдсан элэгдэл	(186.27)	(164.47)	(137.20)	(44.23)	(25.84)	(20.35)
	ҮХ-ийн цэвэр дүн	278.11	299.53	152.10	88.18	43.09	47.82
	Үүнээс: Барилга	148.69	148.70	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	213.30	213.30	200.50	43.01	13.70	16.09
	Тавилга, хэрэгсэл	85.80	84.70	88.80	89.40	55.23	52.08
	Номын фонд	-	-	-	-	-	-
	2.2 Нийтийн тохижилт, бусад	16.59	17.30	-	-	-	-
	2.3 Биет бус хөрөнгүүд	-	-	-	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		278.11	299.53	152.10	88.18	43.09	47.82
ШУС НУС	2.1 Үндсэн хөрөнгө	1,600.16	1,564.50	1,417.10	1,264.29	1,321.21	1,020.70
	Хуримтлагдсан элэгдэл	(970.84)	(888.15)	(734.14)	(598.98)	(589.67)	(503.65)
	ҮХ-ийн цэвэр дүн	629.32	676.35	682.96	665.31	731.54	517.05
	Үүнээс: Барилга	-	-	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	970.82	943.38	860.55	727.06	796.14	583.40
	Тавилга, хэрэгсэл	416.32	415.83	364.72	356.05	350.26	335.11
	Номын фонд	148.50	140.76	127.30	116.65	110.28	102.09
	2.2 Нийтийн тохижилт, бусад	64.52	64.53	64.53	64.53	64.53	0.10
	2.3 Биет бус хөрөнгүүд	0.23	0.33	0.80	1.90	15.50	29.10
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		629.55	676.68	683.76	667.21	747.04	546.15
ШУС-БУС	2.1 Үндсэн хөрөнгө	9,934.84	9,862.03	9,129.68	8,895.44	8,482.15	8,253.97
	Хуримтлагдсан элэгдэл	(8,189.27)	(7,986.41)	(7,127.38)	(6,334.60)	(5,467.22)	(4,551.74)
	ҮХ-ийн цэвэр дүн	1,745.57	1,875.62	2,002.30	2,560.84	3,014.93	3,702.23
	Үүнээс: Барилга	228.95	228.95	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	8,556.04	8,494.67	8,036.29	7,798.09	7,455.64	7,226.70
	Тавилга, хэрэгсэл	892.40	885.33	847.33	861.17	792.81	806.12
	Номын фонд	255.85	251.41	246.06	236.18	233.70	221.15
	2.2 Нийтийн тохижилт, бусад	1.60	1.67	-	-	-	-
	2.3 Биет бус хөрөнгүүд	-	0.32	4.02	10.45	13.61	19.29
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,745.57	1,875.94	2,006.32	2,571.29	3,028.54	3,721.52
ШУС-ХУС	2.1 Үндсэн хөрөнгө	2,501.57	2,239.87	2,328.94	2,039.16	1,787.18	1,598.16
	Хуримтлагдсан элэгдэл	(1,380.36)	(1,258.76)	(1,250.74)	(1,063.39)	(1,036.42)	(999.36)
	ҮХ-ийн цэвэр дүн	1,121.21	981.11	1,078.20	975.77	750.76	598.80
	Үүнээс: Барилга	-	-	-	-	-	-
	Сургалтын машин, т/т	1,595.74	1,397.40	1,517.38	1,242.88	1,017.97	866.75
	Тавилга, хэрэгсэл	619.48	569.16	549.84	553.22	533.09	506.69
	Номын фонд	286.35	273.31	261.72	243.06	236.12	224.03
	2.2 Нийтийн тохижилт, бусад	-	-	-	-	-	0.69
	2.3 Биет бус хөрөнгүүд	1.83	3.49	7.16	11.22	15.27	3.31
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,123.04	984.60	1,085.36	986.99	766.03	602.11